ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМ

2020 оны 06 сарын 18 өдөр Дугаар 11 Улаанбаатар хот

ОХУ-аас МУ-д суугаа Элчин сайд Авивов Искандер Кубарович

АНЭУ-аас МУ-д суугаа Элчин сайд Абдулла Абдулрахман Абдулла Бин Рабия Аль-Тунэйжи

БНТУ-аас МУ-д суугаа Элчин сайд М. Ахмет Язал

БНЧУ-аас МУ-д суугаа Элчин сайд Иржи Бродский

Унгар улсаас МУ-д суугаа Элчин сайд Галошфаи Михай Матиаш

ИБНВУ-аас МУ-д суугаа Элчин сайд Филип Малон

Европын холбооноос МУ-д суугаа Элчин сайд Траян Христеа

БНФУ-аас МУ-д суугаа Элчин сайд Филипп Мэрлин

БНЭУ-аас МУ-д суугаа Элчин сайд М.П. Сингх

Кувейт улсаас МУ-д суугаа Элчин сайд Мохаммад Альмутайри

АХУ-аас МУ-д суугаа Элчин сайд Дэвид Мэтью Восэн

АНУ-аас МУ-д суугаа Элчин сайд Майкл С. Клечески

ХБНГУ-аас МУ-д суугаа Элчин сайд Ёорн Розенберг

Канад улсаас МУ-д суугаа Элчин сайд Катрин Ивкоф

Япон улсаас МУ-д суугаа Элчин сайд Кобаяаши Хироюки

БНХАУ-аас МУ-д суугаа Элчин сайд Цай Вэньруй

Эрхэм ноён\хатагтай Элчин сайд нараа,

Хүний эрхийн форум (ХЭФ) нь COVID-19 цар тахлын энэ хүнд үед Монгол Улсын Засгийн газраас авч буй арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх зорилгоор хөглийн банкуудаас төсөв тэтгэх болон тусгай зориулалтын зээл, мөн Дипломат төлөөлөгчийг газрууд (ДТГ)-ын өөрсдийн санаачилсан буцалтгүй тусламжийн хөтөлбөр хэлбэрээр ирж буй шуурхай тусламжид талархалтай хандахын зэрэгцээ цар тахалтай тэмцэх эрх зүйн орчинг хүний эрхэд суурилсан хандлага, зарчмаар бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэн ажиллаж байна.

Цар тахлын үеэр авч буй аливаа арга хэмжээ нь шуурхай байх шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч НҮБ, олон улсын олон талт хамтын ажиллагааны байгууллага болон

иргэний нийгмийн сүлжээнүүдээс дэлхий нийтэд анхааруулж буй тодорхой хэдэн чиглэлийг онцлон анхаарч ажиллахыг МУ-ын Засгийн газар болон түүнд дэмжлэг үзүүлж буй хоёр талын хамтын ажиллагааны тусламж олгогчдод уриалж байна. Үүнд:

Нэгдүгээрт: Гадаад өрийн хэмжээ нь ДНБ-ий 60%-иас давж, хүнд нөхцөлд байгаа Монгол Улсад ирж буй тусламжийн дийлэнх хэсэг нь мөн л зээлийн хэлбэрээр олгогдож байгаа тул энэхүү хөрөнгийг эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой зайлшгүй хэрэгцээ, КОВИД-19 тархахаас сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах, тус хөрөнгийг салбарын бүтцийн өөрчлөлт, засаглал, төр-хувийн хэвшлийн түншлэл хөгжүүлэх зэрэг **шууд хамааралгүй үйл ажиллагаанд зарцуулахгүй байх.** Тодорхой жишээн дээр тайлбарлахад, ДБГ-ийн КОВИД-19-ийн санхүүжилтийн ихээхэн ($8 тэрбум) хэсгийг хувийн хэвшлийг хөгжүүлэх үндсэн зорилго бүхий Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-аар дамжуулан хэрэгжүүлэх гэж байна. Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх туршлага багатай ОУСК нь тус санхүүжилтийг эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулаагүй нь тогтоогдсон Төр-хувийн хэвшлийн-түншлэл (ТХХТ)-ийн хүрээнд хувийн эмнэлгийн салбарт чиглүүлж, улмаар эрүүл мэндийн салбарыг хувьчлахад зарцуулах замаар цар тахлын үеийн онцгой хэрэгцээг хангахгүй байж болзошгүй хэмээн санаа зовниж байгаагаа сонордуулж байна. Иймд эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлэх татвар төлөгчийн мөнгө нь төрийн үнэгүй үйлчилгээний нөөц ба чадавхыг бэхжүүлэхэд зарцуулахыг уриалж байна.

Хоёрдугаарт: Санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, санхүүжилтийн **ил тод байдлыг хангах замаар авлигаас урьдчилан сэргийлэх** чиглэлээр дараахи арга хэмжээ авахад нь техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг уриалж байна. Үүнд:

- КОВИД-19-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор ирж буй бүх санхүүжилтийг нэгдсэн тусгай санд төвлөрүүлж, бие даасан төсөв боловсруулж, зарцуулах;
- КОВИД-19-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр худалдан авалт хийхдээ тендерийн төлөвлөгөө, тендерт ялагч компанийн нэр, эцсийн ашиг хүртэгч зэрэг мэдээллийг ил тод, нээлттэй зарлан мэдээлэх;
- КОВИД-19-ийн санхүүжилт хүлээн авч, хэрэгжүүлснээс хойш 6 сарын дотор аудитын үнэлгээ хийлгэх нөхцөлийг санхүүжилтийн гэрээнд тусгах.
- КОВИД-ын санхүүжилтийг огт тендергүй олгох эрх зүйн зохицуулалтгүй тул **хуулийн дагуу тендер зарлах,** цаг хугацаа хэмнэх шаардлагатай бол тендерийн жагсаалтыг ил зарлах, ,шалгаруулалтыг хянах боломжийг мэргэжлийн, мэргэшсэн болон иргэний байгууллагуудад олгох.

Гуравдугаарт: Дэлхий нийтэд тулгарч байсан өмнөх хямралуудын үеэр “бүсээ чангалах”, “хүнээс урьд эдийн засгаа аврах” зэрэг зорилго тавин ажилласан нь үр дүнгүй байсныг анхааралдаа авч, юуны өмнө хүнээ аврахыг гол зорилго болгох. КОВИД-19-ийн үеийн эдийн засгийн бодлого тодорхойлохдоо **хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх,** хэрэгжүүлэх явц болон хэрэгжиж дууссаны дараа хүний эрхийн чиглэлээр тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх шаардлагатай. Бодлогоо тодорхойлохдоо “хэнийг ч ардаа орхихгүй” гэсэн Тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлэх, тиймээс нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөнд хамгийн ихээр өртөж буй эмзэг бүлгийн иргэдэд зориулсан **“ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР”** боловсруулан хэрэгжүүлэх, ингэхдээ хөтөлбөрийг төлөвлөх, батлах, гүйцэтгэх, хяналт тавих бүхий л шатанд иргэд, иргэний нийгмийн эрх тэгш оролцоог хангах, үүний тулд дараах асуудад түлхүү анхаарч оролцох:

- Эмзэг бүлгийн иргэд, хүүхэд, эмэгтэйчүүдийг хоол хүнс, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх хамгаалах хэрэгслээр хангах;
- Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах байрны санхүүжилтийг яаралтай шийдэх зохион байгуулалтыг хийх;
- Өрх толгойлсон, орлого багатай зэрэг эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн ажлын байрыг хадгалах, түрээсийг шийдэх, бизнес нь шинэ нөхцөлд дасан зохицоход зориулсан сан ажиллуулах;
- Эмзэг бүлгийн иргэдийн ус, цахилгааны төлбөрийг төлөөгүй гэсэн үндэслэлээр таслахгүй байх, бусад шаардлагатай хамгаалах арга хэмжээ авах.

Дөрөвдүгээрт: Өнөөг хүртэл авч хэрэгжүүлсэн ажлын байр хадгалж буй ААН-ийг дэмжих бодлого эзэндээ хүрэхгүй, зарим нь тунхаг төдий байгаад олон нийт бухимдаж байгааг анхааран үзэж**, ил тод, шударга хэрэгжих, орхигдсон бүлгийг хамруулах чиглэлээр залруулга хийхэд** нь дэмжлэг үзүүлэх**.**

Тавдугаарт: КОВИД-19-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх явцдаа НҮБ-ын хүний эрхийн механизмуудаас гаргаж буй зөвлөмж, удирдамжийг[1] судалж, бодлогодоо тусгах. Энэ хүрээнд НҮБ-ын Гадаад өрийн эксперт Хуан Пабло Бохославскийн “Эдийн засгийн шинэчлэлийг хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний зарчмууд[2]-ын хүрээнд хийх уриалга”, мөн Орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай Илтгэгч Лейлани Фархагийн “Ковид-19 цар тахлын эсрэг нэн тэргүүний хамгаалалт бол Орон байр юм” уриалгыг орчуулан хавсаргав. Тус уриалга нь Монгол Улсын Засгийн газар**, хөгжлийн тусламж үзүүлэгч, бизнесийн хөрөнгө оруулагч ба хэрэгжүүлэгч ААН зэрэг бүх талууд хэрэгжүүлбэл зохих зөвлөмжийг агуулсан. Элчин сайд та өөрийн үзүүлж буй тусламж, мөн компаниудууддаа анхааруулж ажиллахыг уриалж байна.** Үүний зэрэгцээ НҮБ-ын гэрээний хороодоос гаргасан зөвлөмж, уриалгыг МУ-ын хөгжилд оролцогч бүх талууд хэрэгжүүлэх механизм байгуулж, хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг оролцуулахыг уриалж байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМ

БНБТ! Иргэний нийгмийн үндэсний эвсэл
Захиргааны шинэ санаачлага
Иргэдэд туслах хүний эрхийн төв
МОНФЕМНЕТ
Монголын Эмнести Интернэшнл
Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих холбоо
Оюу Толгой Хяналт ТББ
Үндсэн уртраг ТББ
Үнэн хатамж ТББ
Хил хязгааргүй алхам ТББ
Хил хязгааргүй гол мөрөн эвсэл
Хөгжлийн хэлхээ ТББ
Хүний эрх, хөгжил төв
Хэрэглэгч сан

[1] https://www.ohchr.org/Documents/HRBodies/TB/COVID19/Compilation_statements.pdf
[2] https://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?si=A/HRC/40/57

Хувийг: ЗГХЭГ-ын дарга Л. Оюун-Эрдэнээр дамжуулан МУЗГ-т
МУ-ын Гадаад харилцааны сайд Д. Цогтбаатарт

Хавсралт: НҮБ-ын Хөндлөнгийн шинжээчийн уриалга
НҮБ-ын ХЭДКГ-ын КОВИД-19 Удирдамж
НҮБ-ын Орон байртай байх эрхийн Тусгай илтгэгчийн уриалга